



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2023.02.08. № 01/298.
танай _____-ны № _____-т

АЙМАГ, ДҮҮРЭГ (НИЙСЛЭЛ)-ИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 50 дугаар зүйлийн 50.14 дэх хэсэгт “Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно” гэж заасан.

Иймд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын даргын шийдвэрээр цэргийн цол олгогдсон алба хаагчийн тухайн байгууллагынхаа захиалгаар суралцсан, Дотоод хэргийн их сургуульд томилогдон цолтойгоор ажилласан, мөн сургуулийн Онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан хугацааг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан 6 сар тутмыг 8 сард дүйцүүлэн тооцно /дүйцүүлэн тооцох хугацааг 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцно/” гэж заасанд хамруулан алба хаасан 6 сар тутмыг 8 сард дүйцүүлэн тооцож цэргийн тэтгэвэр тогтооно. Харин онцгой байдлын алба хаагчийн хугацаат цэргийн алба хаасан 6 сар тутмыг 8 сард дүйцүүлэн тооцохгүйгээр алба хаасан хугацааг хэвээр нь буюу цэргийн батлах эсхүл архивын лавлагаанд тусгасан хугацаагаар нь тооцно.

2. Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан Цагдаагийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд” гэснийг хассугай” гэж, Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийг “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар

ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж өөрчлөн баталж 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлсэн байна.

Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчийн ажлын байр, албан тушаалыг харгалзахгүйгээр ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, харин цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцон цэргийн тэтгэвэр тогтоох тул Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны “Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасан ажлын байр /албан тушаал/-ны жагсаалт” 01/825, тус газрын 2020 оны “Зөвлөмж хүргүүлэх тухай” 1/1124 дугаар албан бичгийн 3-т заасан албан тушаалын жагсаалтыг цаашид баримтлахгүй болсныг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн Дотоод хэргийн их сургуульд цагдаагийн цолтой ажилласан хугацааг Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасны дагуу нэмэгдүүлэн тооцож цэргийн тэтгэвэр тогтооно.

3.Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

3.1.Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Цагдаагийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 86.2-т заасан хугацаа нь уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон гүйцэтгэх ажилтан, замын хөдөлгөөний зохицуулагчид хамаарахгүй” гэж заасан тул энэ хууль хүчин төгөлдөр болсон 2017 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон гүйцэтгэх ажилтан, замын хөдөлгөөний зохицуулагчид хамаарахгүй. Харин мөн өдрөөс хойш цэргийн тэтгэвэр тогтоолгосон алба хаагчид хуулийн энэхүү зохицуулалт хамаарна.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө цэргийн тэтгэвэр тогтоолгосон иргэн нь цагдаагийн алба хаасан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцуулах хүсэлт гаргасан тохиолдолд цагдаагийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тооцсон тодорхойлолтыг тухайн цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр тогтоолгохын өмнө алба хааж байсан байгууллагын тооцон баталгаажуулсан тодорхойлолтыг үндэслэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг үндэслэн тэтгэврийг нь өөрчлөн тогтоож, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримтлан өөрчлөгдсөн тэтгэврийг олгоно.

3.2. Тахарын албанд ажиллаж байсан алба хаагчдын тус албанд ажилласан хугацааг цагдаагийн албанд ажилласнаар тооцон цэргийн тэтгэвэр тогтоох талаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны А/78 дугаар тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд баримтлах заавар”-ын 5 дугаар зүйлийн 5.10-т дурдан, Тахарын албанаас Цагдаагийн байгууллагад шилжин ирсэн нэр бүхий 367 алба хаагчийн жагсаалтыг хүргүүлсэн.

Иймд Тахарын алба хаагчийн уг албанд ажилласан хугацааг цагдаагийн албанд ажилласнаар тооцон Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу алба хаасан хугацааг нэмэгдүүлэн тооцож цэргийн тэтгэвэр тогтооно. Мөн цэргийн тэтгэвэр авагч нь алба хаасан хугацаагаа нэмэгдүүлэн тооцож тэтгэвэрээ өөрчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд энэ зөвлөмжийн 3.1-д заасны дагуу тэтгэврийг нь өөрчлөн тогтоож болно.

3.3. Цагдаагийн алба хаагчийн цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд сонсогчоор суралцсан, хүүхдээ асрах чөлөөтэй байсан, цагдаагийн байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцсан хугацаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт заасанд хамаарахгүй тул уг алба хаасан 1 жилийг нэмэгдүүлэхгүй хэвээр нь тооцож цэргийн тэтгэвэр тогтоох зэрэг болно.

Хавсралт 5 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

Партизаны гудамж, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14250
Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77,
Цахим шуудан: doc@nema.gov.mn,
Цахим хуудас: www.nema.gov.mn

2023.07.18 № 1/108
танай 12.27 -ны № 01/2447 -т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.АРИУНБОЛД ТАНАА

Тодруулга, санал хүргүүлэх тухай

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.14-т "Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно" гэж заасан. Иймд дээрх хуулийн заалтад дараах тодруулгыг хүргүүлж байна.

Үүнд:

- Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан гэдэгт Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр гадаад, дотоодын их дээд сургууль, коллеж болон мэргэжил олгох, дээшлүүлэх курст суралцан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа,
- Онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан гэдэгт Дотоод хэргийн их сургуульд томилох эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдсон, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр цэргийн цол олгогдсон,
- Онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан гэдэгт Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан зэрэг нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т заасан "Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно" гэсэн заалтад хамаарна.

Харин хугацаат цэргийн алба хаасан гэдэгт зэвсэгт хүчин болон хилийн ба дотоодын цэрэгт хугацаат цэргийн алба хаасан бол дээрх хуулийн заалтад


хамаарахгүй бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар шийдвэрлэгдэнэ.

2. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан байгууллагад ажиллаж байгаад чөлөөлөгдөн Цэргийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т зааснаар эгүүлэн авч болдог. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар зөвлөмжөөр Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэн төрийн тусгай албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахыг хориглодог. Иймд тухай иргэн мэдээллээ өгөхгүй тохиолдолд дээрх хуулийн үндэслэлээр чөлөөлөгдсөн эсэх лавлагаа шаардлагатай болдог.

Иймд хамтран ажиллах 2018 оны 15/09 дүгээр гэрээнд "3.7. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8, 10 дугаар зүйлд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэний мэдээллийг нууцын журмаар гаргуулж авах" гэж нэмж, хугацааг сунгах саналтай байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



П.АРИУНБУЯН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,

Цахим шуудан: info@police.gov.mn,

Цахим хуудас: www.police.gov.mn

2023.01.23

№

01/58

танай

-ны №

-г

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА А.АРИУНБОЛД
ТАНАА

БАЛГ, СБГ-м

Ариунболд

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.” гэж зохицуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, Нийгмийн даатгалын ерөнхий газар хооронд 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулан ажиллаж байгаа бөгөөд уг гэрээний дагуу цагдаагийн албаны тухай хуулийн 86.2 дахь хэсэгт заагдсан албан тушаалтан болон мөрдөгч, ахлах мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаа жолооч зэрэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын цагдаагийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн тооцож, цэргийн байнгын тэтгэвэр тогтоон хуулийн хүрээнд хамтран ажиллаж ирлээ.

Дээрх хуулийн зохицуулалтад цагдаагийн байгууллагын захиргаа, санхүү, мэдээлэл, дүн шинжилгээ, холбоо, технологийн чиглэлийн алба хаагчид болон удирдах албан тушаалтнууд хамаарагдахгүй байсан бөгөөд ийнхүү эрхэлж байгаа ажил албан тушаалаар нь ангилан, нийгмийн баталгааг эдлүүлэхээр заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох тэгш эрхийн зарчимтай нийцэхгүй байсан.

Цагдаагийн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах, хуульд заасан баталгаагаар тэгш хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Тус хуулиар Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэг нь “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.” гэж өөрчлөгдсөн буюу цагдаагийн албанд ажиллаж байгаа бүх алба хаагчдын ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцохоор хуульчилсан.

Иймд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, байгууллага хооронд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний хэрэгжилтийг хангах талаар дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон буюу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө цагдаагийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцуулан тэтгэвэр тогтоолгохоор цэргийн тэтгэвэр авагч нь хүсэлт гаргасан тохиолдолд тэтгэврийг өөрчлөн тогтоох;

2. Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 02 дугар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан Тахарын албанд ажиллаж байсан алба хаагчдын тус албанд ажилласан хугацааг хуулийн өөрчлөлтийн дагуу нэмэгдүүлэн тооцож, цэргийн байнгын тэтгэврийн хугацааг тогтоох;


3. Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.7 дахь хэсэгт заасан "...цэргийн жинхэнэ алба хаасан, цэрэг, цагдаагийн сургуульд (гадаад улсын сургууль орох) сонсогчоор суралцсан" хугацаа нь цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг тогтмол хэрэгжүүлдэггүй тул нэмэгдүүлсэн хугацаанд оруулан тооцохгүй байх;

4. Мөн цагдаагийн байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцах болон хүүхэд асрах чөлөө авахад төрийн албанаас түр чөлөөлдөг тул тухайн хугацааг нэмэгдүүлсэн хугацаанд тооцохгүй байх.

Цагдаагийн байгууллагаас хуулийн хэрэгжилтийг хангах, түүнийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, байгууллага хоорондын ажлыг уялдуулах, алба хаагчдад хуульд заасан баталгааг эдлүүлэх талаар гаргасан санал, зөвлөмжийг хүлээн авч хамтран ажиллахыг хүсье.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД



МОНГОЛ УЛСЫН
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

Хилчний гудамж, 8 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13301
Утас: (976) 7015 5083, Факс: (976) 7015 5001,
Цахим шуудан: info@uia.gov.mn,
Цахим хаяг: www.uia.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ
ТАНАА

2023.02.01 № 03/141
танай _____-ны № _____-т

Хамтран ажиллах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийг “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан.

Тус Их сургуулийн цагдаагийн цолтой албан хаагчид нь Цагдаагийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.5-д “Цагдаагийн алба хаагч бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагын цагдаагийн цолтой алба хаагч нь цагдаагийн алба хаагчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтын хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээх, мөн хуулийн 83-89 дүгээр зүйлд заасан алба хаагчийн болон улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдахаар зохицуулагдсан.

2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 86 дугаар зүйлийн 86,2 дахь хэсэгт “Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно” гэж заасны дагуу тус Их сургуулийн харуул хамгаалалт, жижүүр, жолооч зэрэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчдын цагдаагийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар нэмэгдүүлэн тооцож, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоож ирсэн. Ийнхүү 2017 онд шинэчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн зохицуулалтад захиргаа, санхүү, багш, холбоо мэдээллийн чиглэлийн албан хаагчид болон удирдах албан тушаалтнууд хамаардаггүй байсан.

Иймд 2022 оны “Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Дотоод хэргийн их сургуульд цагдаагийн цолтой ажиллаж буй албан хаагчдын ажилласан хугацааг “Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсэгт зааснаар нэмэгдүүлэн тооцуулах саналтай байгаа тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж, хамтран ажиллана уу.

ЦЭРГИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ХАНГАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ЦАГДААГИЙН УВРАЦЛАА